

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын...ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1-18 дахь заалтад “эрхлэх асуудлын хүрээнд агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны ...ны сарын ...ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**2014. 01. 07**

## **Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Агаарын бохирдлыг бууруулах асуудал нь нийгэм, эдийн засаг, экологийн хүрээг бүхэлд нь хамарсан цогц асуудал юм. Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн түвшин гамшгийн хэмжээнд хүрч, бохирдол, тоосонцрын хэмжээгээрээ дэлхийн хамгийн их бохирдолтой хотын нэг болчихоод байгаа цаг үед энэ асуудлыг шийдвэрлэхэд төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, идэвх санаачлагатай өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа нэн чухал болоод байна.

Агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрээд байгаа нөхцөлд төр, засгийн зүгээс олон чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн хэдий ч эргэлт гарсан, хүмүүсийн амьдралд мэдрэгдэхээр үр дүн гарч өгөхгүй байна. Бохирдуулагч эх үүсвэрүүдийн хувьд хэдийгээр нөлөөллийн төвшин нь харилцан адилгүй хувь хэмжээтэйг харгалзан хамгийн гол боихруулагч эх үүсвэр болох гэр хорооллын утаатай тэмцэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн ч үр дүн нь хүссэн хэмжээнд хүрч чадахгүй байна.

Тиймээс цаашид агаарын бохирдлыг төрийн бүх институцийн оролцоог хангасан ингэснээрээ бүх нийтийн оролцоотой, гамшгийн нөхцөлд тохирсон менежмент, иж бүрэн хандлага, арга барилаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Товчхоноор хэлбэл, аливаа гамшгийн нөхцөлд түүнд тохирсон менежментийг л хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Үүнийг шийдэх гол арга зам нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулинд нэмэлт оруулах замаар бүх яамны чиг үүрэгт нь агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудлыг хуульчлан тогтоож өгөх явдал юм.

Ингэж тогтоосноор институци хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдаж бүх яам өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж түүнийгээ эргэн тайлагнадаг болох юм.

Дээрх үндэслэлээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа. .

## **Хоёр. Хуулийн төслийн хамрах хүрээ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1-18 дахь заалтад нэмэлт оруулахаар төслийг боловсруулсан болно.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм,  
эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар  
авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсанаар төрийн институци хоорондын уялдаа холбоо эрс сайжирч агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаанд нэгдсэн иж бүрэн бодлоготой болох юм. Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр яамдын эрх зүйн үндэс бий болсноор харилцан уялдаатай, нэгдсэн бодлоготой ажилладаг болохын зэрэгцээгээр хяналт,

мониторингийн нэгдсэн тогтолцоо үүсэж үр дүн нь сайжирч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд эерэг бодиттой үр нөлөө үзүүлэх юм.

**Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай аливаа хэлбэрээр зөрчилдөхгүй бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох дагалдах хууль байхгүй болно.

**Төсөл санаачлагчид**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ УХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**2014. 01. 07**

Энэхүү хуулийн төслөөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1-18 дахь заалтад нэмэлт оруулах замаар бүх яамны чиг үүрэгт

нь үйл ажиллагааныхаа хүрээнд агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудлыг хуульчлан тогтоож байгаа юм.

Гамшгийн нөхцөлд буй агаарын бохирдлын асуудал нь төрийн иж бүрэн, өргөн уялдаатай, бүх нийтийн оролцоотой хандлага, арга барил, өөрөөр хэлбэл гамшгийн нөхцөлд тохирсон менежментийг шаардаж буй нь сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн хүссэн хэмжээнд хүрэхгүй буйгаар нөхцөлдөж байна. Тиймээс Засгийн газар, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүн ажиллах хүчин, чармайлтыг дэмжих, эрх зүйн орчинг сайжруулах, төрийн яамдын агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаанд нийтээрээ хуулиар баталгаажуулсан үүргийнхээ дагуу оролцож, үйл ажиллагааныхаа уялдаа холбоог сайжруудах, төр, иргэд, аж ахуйн нагж байгууллагуудын хамтарсан хүчин чармайлт, үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох зорилгоор энэхүү хуулийн төслийг танилцуулж байна. Хуулмйн төсөл ердөө нэг өгүүлбэрийн бүтэцтэй бөгөөд энэ нь “эрхлэх асуудлынхаа хүрээнд агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал” гэж томъёологдож байгаа болно. Энэхүү заалтыг Засгийн газрын тухай хуулийн холбогдох хэсэг, заалтуудад оруулж өгснөөр өмнө дурьдсан эрх зүйн орчин сайжирч агаарын бохирдлын эсрэг нэгдмэл үйл ажиллагааны эрх зүйн үндэс бий болох юм.

Жишээ болгож Хууль зүйн яам, Гадаад харилцааны яамыг авч үзье. Хууль зүйн яам системийн бүх байгууллагадаа үүрэг даалгавао өгч эхлэх, хууль тогтоомжид энэ чиглэлээр дүн шинжилгээ хийх, Экологийн цагдаа бий болгох, цагдаагийн газрын энэ чиглэлийн үйл ажиллагааг хүчтэй, санаачлагатай болгох гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

Гадаад харилцааны яамны хувьд бүх Элчин сайдын яамдууд нь энэ чиглэлийн сайн туршлага, ногоон технологийг судлах, “Ногоон” дипломат үйл ажиллагаа идэвхжснээр Олон улсын байгууллагууд, гадаадын холбогдох яамдтай энэ чиглэлийн хамтын ажиллагаа өргөжиж, гадаадад суугаа Монголчуудыг энэ үйл ажиллагаанд татан оролцуулах боломж нээгдэх юм.

Энэ мэтээр төрийн яамд эрхлэх асуудлынхаа хүрээнд олон талын үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх боломжтой болж агаарын бохирдлын эсрэг төр, хувийн хэвшил, иргэдийн үр дүнтэй хамтын ажиллагааны механизм бүрдэх юм.

**Төсөл санаачлагчид**

**Төсөл**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
З.ЭНХБОЛД ТАНАА**

*2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр*

*Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай*

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ДЭМБЭРЭЛ

А.БАКЕЙ

Р.ГОНЧИГДОРЖ

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Сү.БАТБОЛД

Н.БАТЦЭРЭГ

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БОЛДБААТАР ТАНАА**

2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

*Хуулийн төсөл өргөн мэдүүлэх,  
тов тогтоолгох тухай*

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлон мэдэгдэнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ДЭМБЭРЭЛ

А.БАКЕЙ

Р.ГОНЧИГДОРЖ

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Сү.БАТБОЛД

Н.БАТЦЭРЭГ